



# МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

19 98 оны 7 дугаар сарын 29 өдөр

Дугаар А/914

Улаанбаатар хот

УСАГ Улсын үйлдвэрийн газарын дүрэм батлах тухай

Нэг. Улаанбаатар хотын "УСАГ" улсын үйлдвэрийн газрын дүрмийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Энэхүү дүрэмд нийцүүлэн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн боловсруулж шийдвэрлүүлэхийг "УСАГ" И.Эрдэнэбаатар-т даалгасугай.

Гурав. Энэ захирамж гарсангай холбогдуулан Дүрэм батлах тухай Нийслэлийн Засаг даргын 1997 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн 5-173 дугаар захирамжийг хүчингүй болгонд тооцож байна.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БОГООД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ

*Ж.НАРАНЦАЦРАЛТ*



**УЛААНБААТАР ХОТЫН "УСАГ" УЛСЫН ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ДҮРЭМ**

**ЦЭГ.Нийтлэг үндэслэл**

1.1.Хуулийн этгээд болох Ус сувгийн ашиглалтын газар нь Зөөврийн ус хангамжийн алгитай санхүү болон үйл ажиллагааны хувьд нэгдсэн зохион байгуулалтад орж Монгол Улсын Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нөхөрлөл, компанийн хуулийн дагуу төрийн өмчид үндэслэгдэн байгуулагдсан хязгаарлагдмал хариуцлагатай компани (Улсын үйлдвэрийн газар) хэлбэрээр ажиллана.

1.2.Газрын оноосон нэр нь "УСАГ" бөгөөд (цаашид энэ дүрмэнд "Газар" гэнэ) төв нь Улаанбаатар хотод байрлана.

1.3.Газар нь Нийслэлийн Баянзүрх дүүргийн 3 дугаар хороо, Хөх тэнгэрийн гудамжинд байрлана.Утас 976-1-455055, факс 976-1-450120.

1.4.Газар нь өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээд мөн.

1.5.Газрын дүрмийн сан 874,9 сая төгрөг

а)Үндсэн хөрөнгө 1896,0 сая төгрөг

б)Эргэлтийн хөрөнгө 912,3 сая төгрөг

**ХОЁР.Газрын үйл ажиллагааны эрх хэмжээ**

2.1.Газрыг байгуулах тухай үүсгэн байгуулагчийн шийдвэр гарсан өдрөөс байгуулагдсанд тооцож Нөхөрлөл, компанийн хуулинд заасан журмаар бүртгүүлж хуулийн этгээдийн эрхтэй болно.

2.2.Газар нь өөрийн нэрийн өмнөөс гадаад, дотоодын байгууллагатай эрх зүйн харилцаанд орох, эд хөрөнгө болон эд хөрөнгийн бус эрх эдлэх, үүрэг хүлээх түүнчлэн шүүх, арбитрайн байгууллагад нэхэмжлэгч буюу хариуцагчаар оролцох эрхтэй.

2.3.Газар нь өөрийн салбар нэгж байгуулан ажиллуулж болно.

2.4. Газар нь үйлчилгээний үнийн саналаа Улаанбаатар хотын захирагч болон газрынхаа Төлөөлөн удирдах зөвлөлд оруулан зөвшилцөж шийдвэрлэнэ.

2.5. Газар өөрийн тамга, тэмдэг, бичгийн хэвлэмэл хуудастай байна.

2.6. Ашиглалт, засварын түүхий эд, материал, тоног төхөөрөмжийг гадаад, дотоодын зах зээлээс бие даан бэлтгэнэ.

2.7. Газар нь дараахь хөрөнгийн эрх үүрэгтэй:

а) Өөрийн эд хөрөнгийн бүрэн байдлыг хангаж үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмшиж ашиглах;

б) Үндсэн хөрөнгийг холбогдох хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ дотор захиран зарцуулах;

в) Төвлөрсөн болон Нийслэлийн төсвөөс олгосон хөрөнгийг төсвийн хууль, зардлын зориулалтын дагуу зарцуулж тайлагнах;

г) Ажил үйлчилгээ үзүүлсний үр дүнд олсон ашгийг эрх бүхий байгууллагаас тогтоосон нормативт хэмжээгээр үлдээж хууль, тогтоомжийн дагуу захиран зарцуулах;

д) Үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, төрийн өмчийн бус этгээдэд эзэмшүүлэх, ашиглуулах, шилжүүлэх болон худалдах, хувьчлахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулинд заасан журмыг баримтлана.

2.8. Газар нь дор дурдсан үйл ажиллагааг явуулна:

а) Нийслэлийн хүн ам, байгууллага, аж ахуйн нэгжийн усны хэрэгцээг унд-ахуйн стандартын шаардлагад тохирсон цэвэр усаар байнга тасралтгүй хангах;

б) Бохирдсон усыг зохих шаардлагын дагуу цэвэрлэж зайлуулах;

в) Хэрэглэгчдийн усны алдагдлыг бууруулах, усны бохирдолтын хэмжээнд хяналт тавих;

г) Цэвэр, бохир усанд стандартын дагуу лабораторийн шинжилгээ хийнэ.

#### **ГУРАВ. Газрыг үүсгэн байгуулагчийн эрх**

3.1. Газрыг үүсгэн байгуулагч нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч байна.

3.2.Газрын төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдийг дөрвөн жилийн хугацаагаар үүсгэн байгуулагч томилно.

3.3.Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд хууль бус үйл ажиллагаа явуулах, баримт бичиг хуурамчаар үйлдэх, ажилд хайнга хандвал тэднийг хэдийд ч өөрчилж болно.

3.4.Газрын даргыг Төлөөлөн удирдах зөвлөлийн саналыг үндэслэн Улаанбаатар хотын захирагч томилж, ажлаас чөлөөлнө.

**ДӨРӨВ. Газрын Төлөөлөн удирдах зөвлөл, түүний эрх хэмжээ**

4.1.Газрын эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл байна.

4.2.Төлөөлөн удирдах зөвлөл 3-аас доошгүй гишүүнтэй байна.

4.3.Газрын бизнес төлөвлөгөөг хянаж батална.

4.4.Газрын зохион байгуулалтын бүтэц, ажиллагсадын цалин хэмжээ, урамшууллын журмыг тогтооно.

4.5.Газрын даргыг хөлсөөр ажиллуулах гэрээ байгуулна.

4.6.Газрын өмч хөрөнгийг захиран зарцуулах талаар даргын эрх хэм хэмжээг тогтоож өгнө.

4.7.Дарга болон газрын үйл ажиллагаанд дотоодын хяналт тавина.

4.8.Газрын тайлан тэнцэл, дүрмийн санд оруулах өөрчлөлтийн талаар дүгнэлт гаргаж үүсгэн байгуулагчаар шийдвэрлүүднэ.

4.9.Жилд 1-ээс доошгүй удаа үүсгэн байгуулагчид ажлаа тайлагнана.

4.10.Дараахь асуудлаар өмчлөгчид санал өгч байна:

а)Газрын дүрэмд өөрчлөлт, нэмэлт оруулах;

б)Газрын үйл ажиллагаа, санхүүгийн байдалд тодорхой нөлөө үзүүлэхүйц хамтын ажиллагааны хэлэлцээр, гэрээг хянах;

в)Ус, бохир усны тарифын түвшинд судалгаа хийж өөрчлөлт оруулна.

4.11.Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал улиралд нэгээс доошгүй удаа хуралдана.Гишүүдийн дийлэнх олонхи, хэрэв 3 гишүүнтэй бол гишүүд бүрэн оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно.

4.12.Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж болно.

4.13.Зөвлөлийн хуралд оролцогчдын дийлэнх олонхоор шийдвэр хүчин төгөлдөр болно.Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас тогтоол гаргах бөгөөд түүнд зөвлөлийн дарга гарын үсэг зурж газрын тэмдэг дарна.

4.14.Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмыг төлөөлөн удирдах зөвлөл тогтооно.

4.15.Газрын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн норм, ажиллагсдын тооны норматив, материал зарцуулалтын норм тогтооно.

4.16.Хуульд заасан бусад бүрэн эрх.

#### **ТАВ.Газрын удирдлага, гүүний эрх үүрэг**

5.1.Дарга нь энэ дүрэм болон хөлсөөр ажиллах гэрээнд заасан хугацаанд тогтоож өгсөн эрх хэмжээний дотор газрын өдөр тутмын үйл ажиллагааг удирдана.

5.2.Дарга нь Нийслэлийн засаг дарга болон газрын Төлөөлөн удирдах зөвлөлийн өмнө ажлаа тайлагнана.

5.3.Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал хуралдуулах тухай саналыг түүний дарга буюу гишүүдэд газрын дарга гаргаж болно.

5.4.Дарга нь газрын үйл ажиллагаатай холбоотой гэрээ хэлэлцээрийг Төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний дотор хийнэ.

5.5.Даргатай холбогдон үүссэн маргааныг шүүх хянан шийдвэрлэхэд Төлөөлөн удирдах зөвлөлөөс томилсон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн газрыг төлөөлөн оролцоно.

5.6.Даргын эдлэх эрх,хүлээх хариуцлагын хэмжээ хязгээр,хариуцлагаас чөлөөлөх үндэслэл,хөлс,урамшуулал зэрэг асуудлыг хөлсөөр ажиллах гэрээнд тусгана.

5.7.Дарга дараахь эрх, үүрэгтэй.

а) Дарга нь ажилтныг ажилд авах,чөлөөлөх,сахилгын арга хэмжээ авах,тэдний цалинг тогтоох,

б) Газрыг гадаад, дотоодод итгэмжлэлгүйгээр төлөөлөх,итгэмжлэл олгох,

в)Газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомж гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах;

г)Газрын бизнес төлөвлөгөө боловсруулж Төлөөлөн удирдах зөвлөл, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан биелэлтийг хангах;

д)Газрын үйлдвэрлэл, технологийн нууцад хамаарах мэдээллийг тогтоох;

е)Хөдөлмөрийн хууль тогтоомжид нийцсэн хөдөлмөрийн дотоод журам баталж мөрдүүлэх;

ж)Тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж тэдгээрийн үнэн зөвийг хариуцах;

з)Маргаантай асуудлаар газраа төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргах;

и)Эрх хэмжээнийхээ хүрээнд газрын хэмжээнд дагаж мөрдөх тушаал, заавар гаргах;

к)Төлөөлөн удирдах зөвлөлөөс даргад эрхэлсэн ажлын чиглэлээр тусгайлан даалгасан үүргийг хэрэгжүүлэх;

л)Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

5.8.Дарга нь хувийн эрх ашгийн үүднээс газрын нэрийг ашиглан гэрээ хэлцэл хийхийг хориглоно.

5.9.Дарга өөрийн буруутай үйл ажиллагаа болон холбогдох хууль, тогтоомж, энэ дүрэм, гэрээнд заасан эрхээ хэтрүүлсэн буюу урвуулан ашигласнаас учирсан хохирлыг бүрэн хариуцна.

## ЗУРГАА.Санхүү, бүртгэл

6.1.Санхүү бүртгэлийн систем нь Монгол улсын холбогдох хууль тогтоомж, түүнд орсон өөрчлөлтийн дагуу явагдана.

6.2.Газрын санхүүгийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 1-нээс эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдөр дуусна.Санхүүгийн анхны жил нь газар байгуулагдсан өдрөөс эхэлж хуанлийн жилийн 12 дугаар сарын 31-ний өдөр дуусах ба санхүүгийн сүүлчийн жил нь газрыг татан буулгасан өдрөөр дууссанд тооцно.

6.3. Газар нь Монгол улсын хууль тогтоомжийн дагуу орлогын болон бусад татвар хураамжийг төлнө.

6.4. Газар нь анхан шатны бүртгэлийн баталгаажсан баримтыг үндэслэн дэлгэрэнгүй ба хураангуй бүртгэл хөтлөн, тайлан тэнцлийг улирлаар гаргаж, Татварын алба, санхүүгийн байгууллагад тушаана.

6.5. Газар нь Монгол улсын хууль тогтоомжийн дагуу хөрөнгийн элэгдэл хорогдлын шимтгэлийг тооцно.

6.6. Газрын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих үүргийг хууль тогтоомжид заасан байгууллага хэрэгжүүлнэ.

6.7. Газрын удирдлага нь газрын үйл ажиллагаанд шалгалт хийхэд шаардагдах бүх баримт материалаар хангана.

6.8. Газрын тооцоо, тайлангийн мөнгөн дүнг төгрөгөөр илэрхийлнэ. Бэлэн мөнгө болон банкинд хадгалагдаж буй бусад мөнгөн хөрөнгө, түүнчлэн орлого, зарлага, төлөгдөөгүй өр, шаардлага зэрэг нь анх оруулсан валютын хэлбэрээр байна. Нягтлан бодох бүртгэлийн бичилт хийх зорилгоор төгрөгт хөрвүүлэхэд Монгол банкны тухайн үеийн албан ёсны ханшаар тооцно.

#### **ДОЛОО. Санхүүгийн хяналт**

7.1. Газрын эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, эзэмшилт, ашиглалт, захиран зарцуулалтад эрх бүхий байгууллагууд ерөнхий хяналт, мэргэжлийн хяналт шалгалт, дотоодын хяналт шалгалтыг холбогдох хуулийн дагуу хийлгэнэ.

7.2. Төрийн өмчийн хороо болон эрх бүхий бусад байгууллагын захиалгаар газрын эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, захиран зарцуулалтад хөндлөнгийн магадлан шалгалт хийлгэнэ.

7.3. Газрын аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын мөрөөр шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

#### **НАЙМ. Татан буулгах**

8.1. Газрыг татан буулгах шийдвэрийг үүсгэн байгуулагч хуульд заасан үндэслэлээр гаргана.

8.2. Газрыг татан буулгах тохиолдолд үүсгэн байгуулагчаас төмилсөн комисс татан буулгах ажлыг эрхлэнэ.

8.3. Татан буулгах комисс нь дуусгалтын тайлан тэнцэл гаргаж үүсгэн байгуулагчид танилцуулна.

8.4. Газрыг татан буулгах тохиолдолд нийтэд мэдээлж өр төлбөрийг хуульд заасан дараалал журмын дагуу төлсний дараа үлдсэн хөрөнгийг 3 сарын дотор үүсгэгч байгуулагчид шилжүүлнэ.

#### ЕС.Бусад асуудал

9.1. Энхүү дүрэмд оруулсан нэмэлт өөрчлөлтийг тухай бүр Монгол улсын бүртгэлийн болон эрх бүхий байгууллагад мэдэгдэж бүртгүүлнэ.

9.2. Энэхүү дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд тэдгээр нь дүрмийн салшгүй хэсэг болно.